



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 103

Номгон

Үл хөдлөх хөрөнгийн дуудлагын  
худалдааны доод үнийг шинэчлэн  
тогтоох тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор худалдах доод үнийг тогтоосон Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашины граж, Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй 2 өрөө орон сууц, Шаргалжуут багийн Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд бүртгэлтэй хуучин эмнэлгийн барилгуудын дуудлагын худалдааг 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр, 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд нийт 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул дээрх тогтоолын хавсралтын 1, 3, 4 мөрүүдэд заасан барилгуудын худалдах доод үнийг 50 хувиар;

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 78 дугаар тогтоолоор худалдах шийдвэр гарсан Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй хуучин конторын барилгын дуудлагын худалдааг 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр, 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул худалдах доод үнийг 50 хувиар тус тус бууруулан дуудлагын худалдаа зохион байгуулах шаардлагатайг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 2.2, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашины граж, Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй 2 өрөө орон сууц, Шаргалжуут багийн Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд

1190173



бүртгэлтэй хуучин эмнэлгийн барилга, Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын хуучин барилгын худалдах доод үнийг хавсралтаар тогтоож дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Барилгын нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 11<sup>00</sup> цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;


2.2. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолын хавсралтын 1, 3, 4 мөрүүд, 2019 оны 78 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй хуучин конторын барилга" гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.


4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ХТэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын  
21-ний өдрийн 103 дугаар тогтоолын  
хавсралт

ХУДАЛДАХ ДООД ҮНИЙГ БУУРУУЛЖ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгуу- лалтын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон он	Тоо ширхэг	Анхны өртөг	Газрын хэмжээ	Дуудлагын худалдаан ы доод үнэ	Тайлбар
1	Шинэжинст сум	ЭМТ	Граж	2008.01.0 1	1	1983870	Айлын хашаан д байдаг газаргүй	563 400,0	1976 онд баригдсан 2008 онд ашиглалтад орсон 36м2 талбайтай, хувь хүний эзэмшлийн газар дээр баригдсан. Бүрэн завсар хийх шаардлагатай. АИТХТ- дийн 72 дугаар тогтоолоор доод үнэ 1126800 төгрөгийг 50 хувиар бууруулав. АИТХТ-дийн 72 дугаар тогтоолоор баталсан доод үнэ 1126800 төгрөгийг 50 хувиар бууруулав.
2	Эрдэнэцогт сум	ЗДТГ	Цагдаагийн байр/ 12 айлын орон сууц 1-3	14.12.25	1	1300000 0	Нийтийн орон сууц тул газаргүй	5 869 250,0	1987 онд баригдсан 46,5м2 талбай бүхий 2 өрөөтэй орон сууц, Инженерийн шугам





4	Хүрээмарал сум	ЗДТ Г	Конторын хуучин барилга	1966.01.0 1	1	3708400 0	1294	6 739 000,0	Аймгийн ИТХТ-дийн 2016 оны 10 дугаар тогтоолоор 26 756 884 төгрөгөөр худалдах доод үнийг тогтоосон. 2019 оны 78 дугаар тогтоолоор 50 хувиар бууруулан 13 478 000 төгрөгөөр дуудлагын худалдаа зохиомон байгуулсан боловч оролцогч ирээгүй тул доод үнийг дахин 50 хувиар бууруулав.2019 оны 3 дугаар улирлын байдлаар үлдэгдэл өртөг 11439134 төгрөг
			<b>Дүн</b>					<b>23 896 25,00</b>	

000